



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 04.

Улаанбаатар хот

### КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД "МАСКАА ЗҮҮЦГЭЭ, ГАРАА УГААЯА" 2 ДУГААР АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйл, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм здийн засагт үзүүлэх серөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус Даалгах Нь:

Нэг. Мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх.

1.1 Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Маскаа зүүе, гарaa угааяа" аяныг хэвлэл мэдээллийн байгууллагууд (телевиз, радио, сонин, төрөл бүрийн цахим хуудас, багц мессеж)-аар сурталчилж ажиллах;

1.2 Уг аяны хүрээнд хэвлэмэл хуудас, гарын авлагуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх;

Хоёр. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1 Тус аянд яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяа байгууллагуудаа идэвхтэй хамруулах;

2.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нар төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах;

Гурав. Аяныг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал;

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлгагнах;

Аймаг, нийслэлийн хүрээнд албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж,  
мэдээ тайланг нэгтгэн Улсын Онцгой комиссын Шуурхай штабт 7 хоног бүрийн  
Баасан гарагт цахимаар болон албан бичгээр ирүүлэх.

ДАРГА,  
ШАДАР САЙД *Я.Содбаатар* Я.СОДБААТАР

VXA0168